



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 41953

Арвайхээр

Г Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Үнэлгээний хорооны 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 119 дүгээр дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн багц-1 Тавилга, техник хэрэгсэл хэрэглэгдэхүүн багцыг 80738000 (наян сая долоон зуун гучин найман мянга) төгрөгөөр Баяннайман ХХК-иар, багц-2 Байгалийн ухааны хичээлийн лабораторийн багаж, сургалтын хэрэглэгдэхүүн багцыг 39900000 (гучин есөн сая есөн зуун мянга) төгрөгөөр Шилүүстэй хайрхан ХХК-иар, багц-3 Биеийн тамирын хичээл, спорт залны сургалтын тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүн багцыг 14000000 (арван дөрвөн сая) төгрөгөөр Богдын буян ХХК-иар, багц-4 Дизайн технологийн кабинетын сургалтын багаж хэрэглэгдэхүүн багцыг 12990000 (арван хоёр сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр Шилүүстэй хайрхан ХХК-иар, багц-5 Хөгжмийн кабинет, урлаг залны техник хэрэгсэл хэрэглэгдэхүүн багцыг 17990000 (арван долоон сая есөн зуун ерэн мянга) төгрөгөөр Шилүүстэй хайрхан ХХК-иар тус тус гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Арвайхээр сумын тавдугаар сургууль (Г.Зууннаст)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Арвайхээр сумын 5 дугаар сургуулийн нягтлан бодогч (Н.Сэдэд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011101433